ХУВЬЦАА ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Энэхүү Гэрээг Монгол Улсын Засгийн газар (МУЗГ), Айвенхоу Майнз Монголия Инк ХХК (одоо Оюу Толгой ХХК гэх болсон) (ОТ ХХК), Айвенхоу Майнз Лимитед (Айвенхоу) болон Рио Тинто Интернэшнл Холдинг Лимитед (Рио Тинто)–ийн хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ (Хөрөнгө оруулалтын гэрээ)-тэй холбогдуулан МУЗГ болон Рио Тинтогийн хооронд байгуулж, 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр болов,

ОТ ХХК нь ОТ Төсөлтэй холбоотой Ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж, ОТ Төслийг хэрэгжүүлдэг;

Айвенхоу болон МУЗГ өөрсдийн зуун хувийн өмчит охин компаниудаараа дамжуулан ОТ ХХК-ийн нийт хувьцааны 66 хувь болон 34 хувийг тус тус эзэмшдэг;

МУЗГ болон Айвенхоу нь ОТ Төслийг удирдуулахаар Айвенхоугийн хамгийн том хувьцаа эзэмшигч болох Рио Тинтог сонгох эрмэлзэлтэй байгаа;

Рио Тинто нь тусгаар улс болон ОТ Төслийн түншийнх нь хувьд ОТ Төсөлтэй холбоотой МУЗГ-ын эрх, ашиг сонирхол болон ОТ ХХК, эсхүл ОТ ХХК-ийн хувьцааг шууд, эсхүл шууд бусаар эзэмшигч Айвенхоугийн бусад охин компанийн аливаа хувьцааг Бусдаас хараат этгээд эзэмших бодит нөхцөл байдал үүсэхтэй холбоотой МУЗГ-ын байр суурийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандахыг зөвшөөрч байгаа зэргийг харгалзан:

Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан Талууд дараахь асуудлыг сайтар, үр өгөөжтэй байдлаар хэлэлцэн үзэж, ийнхүү хэлэлцсэнийгээ хангалттай байдлаар нотлохуйц нотлох баримтыг хүлээн авснаа зөвшөөрч дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1. Энэхүү Гэрээнд хэрэглэсэн том үсгээр эхэлсэн бүх нэр томъёо болон хэллэг нь тэдгээрийг хэрэглэсэн агуулгад өөр утга илэрхийлснээс бусад тохиолдолд Хөрөнгө оруулалтын гэрээн дэх утгатай адил утгыг илэрхийлнэ.

2. Рио Тинто нь Айвенхоу, ОТ ХХК, эсхүл ОТ ХХК-ийн хувьцааг шууд, эсхүл шууд бусаар эзэмшигч Айвенхоугийн бусад охин компанид тухай бүр эзэмшиж буй аливаа хувьцаагаа МУЗГ-тай урьдчилан зөвшилцөхгүйгээр, түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Бусдаас хараат этгээдэд өөрөө шууд, эсхүл өөрийн Хамааралтай этгээд (Рио Тинто группын Хяналтанд байдаггүй Айвенхоу Группын гишүүдээс бусад)-ээр дамжуулан худалдах, эсхүл шилжүүлэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

3. МУЗГ нь ОТ ХХК-д тухай бүр эзэмшиж буй аливаа хувьцаагаа Рио Тинтотой урьдчилан зөвшилцөхгүйгээр, түүний зөвшөөрөлгүйгээр Бусдаас хараат этгээд (Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан түүний Хамааралтай этгээдийн аль нэгнээс бусад)-д өөрөө шууд, эсхүл өөрийн Хамааралтай этгээдээр дамжуулан худалдах, эсхүл шилжүүлэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

4. Хөрөнгө оруулалтын гэрээний 14 дүгээр Бүлэг (Маргаан шийдвэрлэх)-ийн заалтууд энэ Гэрээнд шаардлагатай өөрчлөлтүүдийн хамтаар үйлчилнэ.

5. Энэхүү Гэрээг Талууд заавал дагаж биелүүлэх бөгөөд Монгол Улсын хууль Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулж, тайлбарлана.

6. Энэхүү Гэрээ нь түүний зохицуулсан асуудлаар талуудын хооронд урьд байгуулсан бүх гэрээ, ойлголцлыг орлож үйлчилнэ.

7. Тал бүр энэхүү Гэрээг байгуулж хэрэгжүүлэх, түүнд заасан үүргийг биелүүлэх бүрэн эрх, хууль ёсны эрх мэдэлтэй гэдгээ бусад талууддаа баталж байна.

8. Энэхүү Гэрээг монгол, англи хэлээр тус бүр үйлдэх бөгөөд Тал тус бүр хэл тус бүр дээрх нэг хувийг хадгална. Монгол, англи хэл дээрх эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд хэрэв хоёр хэл дээрх эх бичвэрүүдийг тайлбарлахтай холбоотой эрх зүйн маргаан гарвал англи дээрх эх бичвэрийг баримталж байхаар Талууд харилцан тохиролцов.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН, энэхүү Гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгчид Гэрээний эхэнд заасан өдөр гарын үсэг зурав.

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж: **Эрдэс баялаг, эрчим хүчний сайд** **Д. Зоригт**	Гарын үсэг: .....
Сангийн сайд **С.Баярцогт**	Гарын үсэг: .....
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд **Л.Гансүх**	Гарын үсэг: .....

Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компанийг төлөөлж: **Рио Тинто компанийн Зэсийн Группийн Ерөнхий захирал Эндрью Хардинг**	Гарын үсэг: .....

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн

Гарын үсэг /Signature/ .....
2011. оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION